

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН
ТООЦОО**

/Шүүх шинжилгээний тухай хуулийн төсөл/

УЛААНБААТАР ХОТ
2021 ОН

АГУУЛГА

Нэг. Ерөнхий үндэслэл

Хоёр.Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төсөл батлагдан гарснаар иргэнд үүсэх зардлын тооцоо:

- 2.1.иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2.2.цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- 2.3.тоон үзүүлэлтийг тооцох;
- 2.4.нийт дүнг тооцож гаргах;
- 2.5.хялбарчлах боломжийг шалгах;

Гурав.Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо:

- 3.1.хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 3.2.нэг бүрийн зардлыг тооцох;
- 3.3.тоон үзүүлэлтийг тооцох;
- 3.4.нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 3.5.хялбарчлах боломжийг шалгах;
- 3.6.нэмэлт зардлыг тооцох;

Дөрөв.Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төсөл батлагдан гарснаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо:

- 4.1.төрийн байгууллагад шинээр нэмэгдэж байгаа болон өргөжиж байгаа чиг үүргийг тогтоох;
- 4.2.уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох;
- 3.3.гарах зардлыг тооцох;
- 3.4.зардлыг нэгтгэн тооцох;
- 3.5.хувилбарыг нягталж зардлыг бууруулах боломжийг эрэлхийлэх;

Тав.Дүгнэлт

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Нэг.ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдснаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан зардлын тооцоог гаргав.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдснаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэх болно.

Хуулийн төслөөс иргэн, хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлохдоо уг хуулийн төсөл нь “шинэчилсэн найруулга” хэлбэрээр бичигдэж байгаа буюу уг харилцаа нь нэгэнт журамдлагдсан байх тул шинээр болон өмнө гүйцэтгэж байсан үүргээс өргөжүүлсэн үүргийн хүрээнд хязгаарласан болно.

Хуулийн төслөөр одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн хүрээнд хийгдэж буй шинжилгээний цар хүрээг өргөжүүлсэн болон шинээр бий болж буй үүрэгт зардал тооцогдож байгаа тул бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдол нилээд байсан тул аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаалах, салбарын мэргэжилтнүүдээс санал авах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

ХОЁР.ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг тооцоолохдоо дараахь дарааллыг баримтална. Үүнд:

- Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох
- Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох
- Тоон үзүүлэлтийг тооцох
- Нийт дүнг тооцож гаргах
- Хялбарчлах боломжийг шалгах

2.1.Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох:

Энэ үе шатанд Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төсөлд тусгагдсан иргэний гүйцэтгэх үүргийг болон түүний мэдээллийн агуулгыг нэг бүрчлэн тодорхойлов. Хуулийн төслөөр иргэн гэдэгт “Шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч иргэн түүнчлэн тус зөвшөөрлийг эзэмшигч”-ийг багтаан үзсэн болно. Уг хуулийн төслөөр иргэн нь дараахь үүргийг шинээр гүйцэтгэхээр байна. Үүнд:

Иргэний гүйцэтгэх үүрэг, түүний агуулгыг гаргасан байдал:

10.1.Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас бусад этгээд хийх шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хууль зүйн болон тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан шийдвэрээр 5 жилийн хугацаагаар олгоно.

2.2.Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох:

Энэ үе шатанд дараахь үйл ажиллагаанд хийгдэнэ.

- Үүргийг гүйцэтгэхэд буюу үүргийг агуулга бүрийг бүрдүүлэхэд иргэний зүгээс хийгдэх стандарт ажиллагааг тогтоох
- Уг стандарт ажиллагаанд зарцуулах хугацааг тодорхойлох
- Иргэнээс шууд гарах зардлыг мөнгөн дүнгээр тодорхойлох

Өмнөх шатанд тодорхойлсон үүрэг, түүний агуулгыг бүрдүүлэхэд иргэнээс зарцуулах хугацааг бодит нөхцөл байдалд тулгуурлан ердийн дундаж хугацаагаар баримжаалан гаргасан болно.

Одоо мөрдөгдөж буй Шүүхийн шинжилгээний тухай хуулийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2017 оны А/115, А/176, 142 дугаар тушаалаар баталсан “Шүүх эмнэлгийн төлбөрт үйлчилгээний журам”-ын дагуу одоо хийгдэж байгаа шинжилгээнүүд дээр тогтоосон төлбөрийг иргэнээс авч байгаа. Өөрөөр хэлбэл эдгээр зохицуулалт буюу зардал бий болгосон үүргүүд нь өмнө байсан зохицуулалт байх тул хуулийн төслөөр иргэнд зөвхөн шинээр бий болгож байгаа үүргийг авч үзэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Иймд хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.1 буюу “Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас бусад этгээд хийх шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хууль зүйн болон тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан шийдвэрээр 5 жилийн хугацаагаар олгоно” гэсэн заалтыг сонгож энэхүү үүргээс бий болох зардлыг тооцлоо. Түүнчлэн иргэнд үүсэх зардлын зөвхөн цаг хугацааны ачааллаар тооцдог болохыг энд дурдах нь зүйтэй.

Хүснэгт 1

Д/д	Гүйцэтгэх үүрэг	Мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа
1	10.1 Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас бусад этгээд хийх шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хууль зүйн болон тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан шийдвэрээр 5 жилийн хугацаагаар олгоно.	Холбогдох салбарын яаманд албан бичгээр хүсэлт гаргах	Харьяалах салбарын яаманд хүргүүлэх албан бичиг боловсруулах	15
			Холбогдох баримтыг хуулбарлан хавсаргах	20
			Шуудангаар хүргүүлэх	15
		Зөвшөөрөл авах	Зөвшөөрлийн гэрчилгээ болон шинжээчийн тэмдэг, дүгнэлтийн маягыг авах	20
НИЙТ ЗАРЦУУЛАХ ХУГАЦАА /дээрх үүргийг нэг удаа хэрэгжүүлэхэд иргэний зарцуулах хугацаа/				70 минут

2.3.Тоон үзүүлэлтийг тооцож гаргах:

Өмнөх хэсэгт дурдагдсан Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төслөөр иргэн шинээр гүйцэтгэхээр болж байгаа үүргийг хэдэн иргэн, жилд хэдэн удаа хэрэгжүүлэхийг энэ үе шатанд тооцоолон гаргана. Үүнийг аргачлалын дагуу дараахь томъёогоор тооцно.

ТООН ҮЗҮҮЛЭЛТ=ТОХИОЛДЛЫН ТОО х ДАВТАМЖИЙН ТОО

Тохиолдлын тоог гаргах асуудал нь манай тохиолдлын хувьд бага зэрэг хүндрэлтэй байсан болно. Учир нь шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийгдэж буй шинжилгээн дээр нэгдсэн тоо баримтгүй, албан ёсны статистик байдаггүй болно. Шүүхийн шинжилгээний байгууллагаас буцаасан 2018, 2019 оны шинжилгээний тоог үндэслэн тохиолдлын тоог гаргав.

Хүснэгт 2

Д/д	Гүйцэтгэх үүрэг	Тохиолдлын тоо	х	Давтамжийн тоо	=	Тоон үзүүлэлт
1	10.1 Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас бусад этгээд хийх шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хууль зүйн болон тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан шийдвэрээр 5 жилийн хугацаагаар олгоно.	12	х	1	=	12

2.4. Нийт дүнг тооцоолж гаргах:

Энэ шатанд Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төслийн хүрээнд зөвшөөрөл хүсэгч иргэнд шинээр бий болсон үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тэдэнд үүсэх

ачааллыг цаг хугацаагаар тооцоолон гаргана. Иргэнд үүсэх ачаалал нь өмнөх үе шатанд тооцоолон гаргасан цаг хугацааны зарцуулалтыг тоон үзүүлэлтээр үржүүлснээр тодорхойлогдоно.

АЧААЛАЛ=ЦАГ ХУГАЦААНЫ ЗАРЦУУЛАЛТ х ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Хуулийн төсөлд тусгасан дээрх үүргийг хэрэгжүүлэхэд дараахь мөнгөн зардал гаргахаар тооцооллоо.

Хүснэгт 3

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэн хуульд заасан үүргийг гүйцэтгэхэд үүсэх цаг хугацааны ачаалал				
Д/д	Гүйцэтгэх үүрэг	Зарцуулах хугацаа	Тоон үзүүлэлт /хамрагдагсдын тоо/	Нийт иргэнд үүсэх цаг хугацааны ачаалал
1	10.1 Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас бусад этгээд хийх шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хууль зүйн болон тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан шийдвэрээр 5 жилийн хугацаагаар олгоно	70	12	840
Иргэнд үүсэх нийт ачаалал				840 мин

Иргэнд үүсгэж байгаа нийт мөнгөн зардлыг тооцоолохдоо нэрлэгдсэн тухайн үүргийг гүйцэтгэхэд хууль, тогтоомжид заасан мөнгөн дүн бүхий зардлыг тоон үзүүлэлтээр үржүүлэх замаар тооцоолон гаргана.

Хүснэгт 4

Хуулийн төсөл батлагдсанаар иргэн хуульд заасан үүргийг гүйцэтгэхэд үүсэх мөнгөн зардал						
Д/д	Гүйцэтгэх үүрэг	Тоон үзүүлэлт	х	Мөнгөн зардал	=	Нийт мөнгөн зардал
1	Холбогдох бичиг баримтыг хуулбарлан хувилах	12	х	500	=	6,000
2	Шуудангийн зардал	12	х	2,000	=	24,000
НИЙТ МӨНГӨН ЗАРДАЛ						30,000

2.5.Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах:

Хуулийн төслөөр иргэнд үүсэх зардлыг тооцооны судалгаагаар Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтад заасны дагуу иргэдэд үүсч байгаа үүргийг хэрэгжүүлэхэд иргэнээс шаардагдах мөнгөн болон цаг хугацааны ачааллыг тооцоолов. Тооцооллыг гаргахдаа хуулийн төслөөр иргэнд шинээр бий болсон үүргийг

хэрэгжүүлэхийн тулд иргэнээс шаардсан баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэхийн тулд иргэний гүйцэтгэх үйл ажиллагааг гаргах замаар ёсны эх сурвалжийг ашиглан баримжаалах замаар тогтоов.

Иргэнд үүсэх зардал нь цаг хугацаагаар тооцогдох бөгөөд жилд дунджаар 12 иргэн зөвшөөрөл хүссэн өргөдлийг гаргаж шинжээчийн зөвшөөрөлтэй болно гэж үзвэл хуулийн төсөлд тусгагдсан ажлыг гүйцэтгэхэд нийт 70 минут зарцуулах тооцоолол гарч байна.

Мөнгөн дүгээр илэрхийлэгдэх зардал буюу үүргийг гүйцэтгэхэд холбогдох материалыг хувилж олшруулах, шуудангаар хүргүүлэх зардалд нийт 30,000 төгрөг зарцуулагдахаар тооцоолол гарсан болно.

ГУРАВ.ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Энэ хэсэгт Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана. Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараахь үе шаттайгаар тооцоолно.

Үүнд:

- Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох
- Нэг бүрийн зардлыг тооцох
- Тоон үзүүлэлтийг тооцох
- Нийт зардлыг дүнг тооцож гаргах
- Хялбарчлах боломжийг шалгах
- Нэмэлт зардлыг тооцох

3.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох:

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдэд ямар үүргийг шинээр бий болгож байгааг тодорхойлж уг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгийн агуулгыг тодорхойлсны үндсэн дээр зардлын тооцоог хийх болно.

Засгийн газрын 2019 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2.2-т “Хуулийн этгээдийн хувьд хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах мөнгөн зардлыг тооцно” гэж заасан.

10.1 Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас бусад этгээд хийх шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хууль зүйн болон тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан шийдвэрээр 5 жилийн хугацаагаар олгоно

3.2.Нэг бүрийн зардлыг тооцох:

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Шүүхийн шинжилгээний тухай хуульд байхгүй шинээр үүсч байгаа шинжилгээний төрлийг нэмэгдүүлсэн бөгөөд хуулийн этгээдийн хувьд экологийн шинжилгээ, үнэлгээний шинжилгээ, барилгын шинжилгээнд

хохирогч болон холбогдогчоор оролцоход тухайн шинжилгээний төлбөртэй тохиолдолд төлбөрийг төлөх зардал гарах юм.

Мөн хуулийн төсөлд зөвшөөрлийг иргэн хуулийн этгээдэд олгохоор тусгагдсан. Иймд шинжээчийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг авах үүрэг нь иргэнд зардал тооцсонтой адил агуулгатай байна.

Стандарт үйл ажиллагаа болон зарцуулах хугацааг тодорхойлохдоо Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтад заасан хугацааг харгалзан үзэхийн хамт бусад ижил төстэй ажил үйлчилгээг ердийн дундаж албан хаагч гүйцэтгэх хугацааг мөн үндэслэсэн болно.

Ажлын хөлсийг тооцож гаргахдаа ажилтанд олгох сарын үндсэн цалинг ажиллах хугацаанд хувааж ажлын хөлсийг өдөр, цаг, минутаар гаргана. Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар нэг ажилтанд ногдох сарын дундаж цалин 2020 оны байдлаар 1,269.1 мянган төгрөгөөр тооцож авсан. Түүнчлэн ажиглах хугацааг тооцоолохдоо Хөдөлмөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн цагийг үндэслэв.

Хүснэгт 5

Ажлын хөлс = Үндсэн цалинг : ажиллах хугацаа
1,269,100 : 22 өдөр : 8 цаг =7,210 төгрөг

Дээрх үүргийг хэрэгжүүлэхэд нэг хуулийн этгээдэд үүсгэж байгаа зардлыг үйл ажиллагаа тус бүрт зарцуулж буй хугацааг ажлын хөлсөөр үржүүлж замаар тооцоолох юм.

3.3.Тоон үзүүлэлтийг тогтоох:

Энэ үе шатанд өмнөх үе шатуудад тогтоосон Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төсөл батлагдан гарснаар бий болсон дээрх үүргийг хичнээн хуулийн этгээд жилд хэдэн удаа гүйцэтгэх вэ гэдгийг хуанлийн нэг жилээр тооцоолон гаргах юм.

Энэ үзүүлэлтийг гаргахын тулд тохиолдлын тоо болон давтамжийг холбогдох статистик мэдээ ашиглан тодорхойлж гаргах бөгөөд тэдгээрийн үржвэрээр тоон үзүүлэлт илэрхийлэгдэх юм.

$$\text{ТОХИОЛДЛЫН ТОО х ДАВТАМЖ} = \text{ТООН ҮЗҮҮЛЭЛТ}$$

Тохиолдлын тоог тооцоход нэгдсэн статистик тоо байхгүй тул өмнө иргэнд тооцсон тохиолдлын тоог баримжаалсантай адилаар баримжаалж тооцно.

3.4.Нийт захиргааны зардлын дүнг тооцож гаргах:

Энэ үе шатанд өмнөх үе шатанд гаргасан үүрэг тус бүрт ногдох нэг бүрийн зардлыг тоон үзүүлэлтээр үржүүлснээр гаргах юм.

$$\text{НЭГ БҮРИЙН ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ х ТООН ҮЗҮҮЛЭЛТ} = \text{НИЙТ ЗАРДАЛ}$$

Хүснэгт 6

Д/д	Гүйцэтгэх үүрэг	Нэг бүрийн зардал	х	Тоон үзүүлэлт	=	Нийт зардал
1	10.1 Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас бусад этгээд хийх шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хууль зүйн болон тухайн салбарын	7,210	х	12	=	86,520

	асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан шийдвэрээр 5 жилийн хугацаагаар олгоно					
						86,520 төгрөг

3.5.Нэмэлт зардлыг тооцох:

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийн этгээд буюу зөвшөөрөл эзэмшигч нь холбогдох баримт бичгийг хуулбарлан харьяа яаманд хүргүүлэхтэй холбоотой мөнгөн зардал буюу хувилж олшруулах болон шуудангаар хүргүүлэх зэрэг зардлыг бусад зардал гэсэн ойлголтод хамруулах юм.

Хүснэгт 7

Д/д	Зардлын нэр	Зарцуулах мөнгөн дүн	Тохиолдлын тоо	Нийт
1	Баримт бичгийг хуулбарлан хувилах	500	12	6,000
2	Шуудангийн зардал	2,000	12	24,000

Иймээс хуулийн этгээдэд үүсэх мөнгөн зардал $86,520+24,000=110.520$ төгрөг байна. Уг хуулийн төсөлд тусгасан хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн дээрх заалт нь шинээр шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч байгаа аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа бүх хуулийн этгээдэд хамааралтай байх бөгөөд ийнхүү аж ахуй эрхлэгч нийт 12 хуулийн этгээд тус бүрт үүсэх мөнгөн зардал юм.

ДӨРӨВ. ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДАГУУ УЛСЫН ТӨСӨВТ ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангахад хамгийн гол чиг үүргийг хүлээгч байгууллага нь Шүүхийн шинжилгээний байгууллага юм. Нөгөө талаас уг хуулийн төсөлд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиас ялгаатай шинээр орж байгаа чиг үүргийг Шүүхийн шинжилгээний байгууллага гүйцэтгэхээр хуулийн төсөлд тусгагдсан байх тул Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төсөл батлагдан гарснаар Шүүхийн шинжилгээний байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцоолсон болно. Чиг үүргийг сонгож авахдаа Шүүхийн шинжилгээний байгууллагын одоо хэрэгжүүлж байгаа чиг үүргийг хуулийн төсөлд нэмж өргөжүүлсэн болон шинээр нэмэгдэж байгаа чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардал ачааллыг тооцоолов. Хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцоолохдоо дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

4.1. төрийн байгууллагад шинээр нэмэгдэж байгаа болон өргөжиж байгаа чиг үүргийг тогтоох;

4.2. Уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох;

4.3. Гарах зардлыг тооцох;

4.4. Зардлыг нэгтгэн тооцох;

4.5.Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

4.1.Гүйцэтгэх чиг үүргийг тогтоох:

Энэ үе шатанд төрийн байгууллагын ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон жилд гүйцэтгэх тоо буюу тохиолдлын тоо, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт ажлын цаг гэсэн 3 үзүүлэлтийг гаргана.

Хуулийн төсөл дэх төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг /ажил үйлчилгээ/, түүний агуулгыг тодорхойлбол: Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр дараах чиг үүргийг Шүүхийн шинжилгээний байгууллага одоо хэрэгжүүлж байгаа чиг үүрэг дээрээ нэмж гүйцэтгэхээр байна.

- Криминалистикийн болон тоон технологийн шинжилгээ. /Энэ төрлийн шинжилгээг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд хийж байгаа боловч мөр судлал, галт зэвсэг, компьютер дүрс бичлэг, авто техникийн шинжилгээг зөвхөн Улаанбаатар хотод буюу Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хийдэг. Шүүхийн шинжилгээний тухай хууль батлагдсанаар Нийслэлийн шүүхийн шинжилгээний газар, аймаг орон нутгийн шүүхийн шинжилгээний албадууд энэ төрлийн шинжилгээнүүдийг хийх боломжтой болох юм/
- Шүүх эмнэлгийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах /Энэ төрлийн шинжилгээг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд хийж байгаа боловч шинжээч эмч, туслах ажилтны орон тоо хангалтгүй байдаг/
- Хими, биологи, физик, ДНХ шинжилгээ хийж дүгнэлт гаргах. /Хими, биологи, физик, ДНХ шинжилгээг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хийдэг бөгөөд орон нутгийн шүүхийн шинжилгээний албадууд шинжилгээний объектыг төврүү ирүүлдэг. Шүүхийн шинжилгээний тухай хууль батлагдсанаар Нийслэлийн шүүхийн шинжилгээний газар, аймаг орон нутгийн шүүхийн шинжилгээний албадууд энэ төрлийн шинжилгээнүүдийг хийх боломжтой болох юм.
- Эдийн засгийн болон үнэлгээ тогтоох шинжилгээ хийж дүгнэлт гаргах: /Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Шүүхийн шинжилгээний тухай хуулийн дагуу эдийн засгийн шинжилгээг хийж байгаа бөгөөд хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар үнэлгээний шинжилгээг хийх боломжтой болох юм./
- Инженер-техникийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах: /Энэ төрлийн шинжилгээг одоо Шүүхийн шинжилгээний байгууллага дээр хийдэггүй бөгөөд хууль батлагдсанаар инженер техник, барилга гэх зэрэг шинжилгээг хийх боломжтой юм./

4.2.Чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох:

Тухайн чиг үүрэг, түүнд хамаарах ажил үйлчилгээг хэрэгжүүлэх хугацаа болон уг ажил үйлчилгээг нэг жилд хэдэн удаа / хэдэн иргэн, хуулийн этгээд/ гүйцэтгэх тоо /тохиолдлын тоо/, шаардагдах нийт ажлын цаг гэсэн гурван үзүүлэлтээр тооцоолон гаргана.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо Шүүхийн шинжилгээний байгууллагын асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй харилцан санал солилцож болон шинжилгээг хийх жишиг хугацааг баримжаалан тогтоолоо.

1. Криминалистикийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах.

1.1 Криминалистикийн мөр судлалын шинжилгээг хийж дүгнэлт гаргахад шаардлагатай хүний нөөцийн тооцоо:

Хүснэгт 7

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа		Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /минутаар/
		минутаар	цагаар		
Криминалистикийн шинжилгээг хийж дүгнэлт гаргах	Шинжилгээ хийлгэх тухай мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, улсын байцаагчийн хүсэлт, объектыг хүлээн авах, танилцах	25		5666	141650
	Хүсэлттэй танилцаж, шинжилгээний объектод үзлэг хийх	720		5666	4079520
	Туршилт загвар авах	480		5666	2719680
	Шинжилгээг хийх	480		5666	2719680
	Гэрэл зургийн үзүүлэлт хийх	300		5666	1699800
	Дүгнэлт бичих	45		5666	254970
	Дүгнэлт хэвлэх	15		5666	84990
	Дүгнэлтийг танилцуулж хаалгах	15		5666	84990
	Дүгнэлт хүлээлгэн өгөх хугацаа	15		5666	84990
НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА					11870270

Шинжилгээ хийлгэх хүсэлт, объектыг хүлээн авч танилцах хугацаа нь тухай шинжилгээний цар хүрээ объектийн тооноос шууд хамаарч харилцан адилгүй байдаг тул дунджаар тооцсон болно.

Тохиолдлын тоог сүүлийн 6 жилийн хугацаанд хийсэн шинжилгээний объектийн дундаж тоогоор тооцов.

Шаардлагатай хүний нөөц = $11870270 \text{ минут} : 60 = 197837.83 \text{ цаг} : 8 \text{ цаг} = 24729.72 \text{ ажлын өдөр} : 200 \text{ ажлын өдөр}^1 = 123,6 \text{ хүн}$

Өөрөөр хэлбэл “улсын хэмжээнд мөр судалын шинжилгээг хамгийн багадаа 1 объекттой шинжилгээ хийнэ гэж үзэн” чиг үүргийг хэрэгжүүлэхэд Шүүхийн шинжилгээний байгууллагад 123,6 хүн буюу ойролцоогоор 124 албан хаагчийн орон тоо нэмэгдэх шаардлагатайг тооцоолов.

1.2 Криминалистикийн галт зэвсгийн шинжилгээг хийж дүгнэлт гаргахад шаардлагатай хүний нөөцийн тооцоо:

¹ Тооцоог нэг жилээр гаргаж байгаа бөгөөд Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийг баримталсан болно.

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа		Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /минутаар/
		минутаар	цагаар		
Криминалистикийн шинжилгээг хийж дүгнэлт гаргах	Шинжилгээ хийлгэх тухай мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, улсын байцаагчийн хүсэлт, объектыг хүлээн авах, танилцах	15		5021	75315
	Хүсэлттэй танилцаж, шинжилгээний объектод үзлэг хийх	360		5021	1807560
	Шинжилгээг хийх	1200		5021	6025200
	Гэрэл зургийн үзүүлэлт хийх	120		5021	602520
	Дүгнэлт бичих	300		5021	1506300
	Дүгнэлт хэвлэх	20		5021	100420
	Дүгнэлтийг танилцуулж хаалгах	15		5021	75315
	Дүгнэлт хүлээлгэн өгөх хугацаа	15		5021	75315
НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА					10267945

Шинжилгээ хийлгэх хүсэлт, объектыг хүлээн авч танилцах хугацаа нь тухай шинжилгээний цар хүрээ объектийн тооноос шууд хамаарч харилцан адилгүй байдаг тул дунджаар тооцсон болно.

Тохиолдлын тоог 2019 онд хийсэн шинжилгээний объектийн тоогоор тооцов.

Шаардлагатай хүний нөөц = 10267945 минут : 60 = 171132.41 цаг : 8 цаг = 21391.5 ажлын өдөр : 200 ажлын өдөр² = 106.9 хүн

Өөрөөр хэлбэл “улсын хэмжээнд галт зэвсгийн шинжилгээг хамгийн багадаа 1 объекттой шинжилгээ хийнэ гэж үзэн” чиг үүргийг хэрэгжүүлэхэд Шүүхийн шинжилгээний байгууллагад 106.9 хүн буюу ойролцоогоор 107 албан хаагчийн орон тоо нэмэгдэх шаардлагатайг тооцоолов.

1.3 Криминалистикийн гарын мөрийн шинжилгээг хийж дүгнэлт гаргахад шаардлагатай хүний нөөцийн тооцоо:

² Тооцоог нэг жилээр гаргаж байгаа бөгөөд Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийг баримталсан болно.

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа		Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /минутаар/
		минутаар	цагаар		
Криминалистикийн шинжилгээг хийж дүгнэлт гаргах	Шинжилгээ хийлгэх тухай мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, улсын байцаагчийн хүсэлт, объектыг хүлээн авах, танилцах	30		14333	260340
	Хүсэлттэй танилцаж, шинжилгээний объектод үзлэг хийх	60		14333	859980
	Шинжилгээг хийх	120		14333	1719960
	Гэрэл зургийн үзүүлэлт хийх	90		14333	1289970
	Дүгнэлт бичих	180		14333	2579940
	Дүгнэлт хэвлэх	20		14333	286660
	Дүгнэлтийг танилцуулж хаалгах	15		14333	214995
	Дүгнэлт хүлээлгэн өгөх хугацаа	15		14333	214995
НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА					7426840

Шинжилгээ хийлгэх хүсэлт, объектыг хүлээн авч танилцах хугацаа нь тухай шинжилгээний цар хүрээ объектийн тооноос шууд хамаарч харилцан адилгүй байдаг тул дунджаар тооцсон болно.

Тохиолдлын тоог сүүлийн 6 жилийн хугацаанд хийсэн шинжилгээний дунджаар тооцов.

Шаардлагатай хүний нөөц = 7426840 минут : 60 = 123780,6 цаг : 8 цаг = 15472,5 ажлын өдөр : 200 ажлын өдөр³ = 77,3 хүн

Өөрөөр хэлбэл “улсын хэмжээнд гарын мөрийн шинжилгээг хамгийн багадаа 1 объекттой шинжилгээ хийнэ гэж үзэн” чиг үүргийг хэрэгжүүлэхэд Шүүхийн шинжилгээний байгууллагад 77,3 хүн буюу ойролцоогоор **77** албан хаагчийн орон тоо нэмэгдэх шаардлагатайг тооцоолов.

1.4 Криминалистикийн бичиг баримтын шинжилгээг хийж дүгнэлт гаргахад шаардлагатай хүний нөөцийн тооцоо:

Хүснэгт 10

³ Тооцоог нэг жилээр гаргаж байгаа бөгөөд Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийг баримталсан болно.

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа		Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /минутаар/
		минутаар	цагаар		
Криминалистикийн шинжилгээг хийж дүгнэлт гаргах	Шинжилгээ хийлгэх тухай мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, улсын байцаагчийн хүсэлт, объектыг хүлээн авах, танилцах	20		21093	421860
	Хүсэлттэй танилцаж, шинжилгээний объектод үзлэг хийх	60		21093	1265580
	Шинжилгээг хийх	330		21093	6960690
	Гэрэл зургийн үзүүлэлт хийх	180		21093	3796740
	Дүгнэлт бичих	300		21093	6327900
	Дүгнэлт хэвлэх	20		21093	421860
	Дүгнэлтийг танилцуулж хаалгах	15		21093	316395
	Дүгнэлт хүлээлгэн өгөх хугацаа	15		21093	316395
НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА					19827420

Шинжилгээ хийлгэх хүсэлт, объектыг хүлээн авч танилцах хугацаа нь тухай шинжилгээний цар хүрээ объектийн тооноос шууд хамаарч харилцан адилгүй байдаг тул дунджаар тооцсон болно.

Тохиолдлын тоог Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд сүүлийн 6 жилийн хугацаанд хийсэн шинжилгээний дундаж объектийн тоогоор тооцов.

Шаардлагатай хүний нөөц = $19827420 \text{ минут} : 60 = 330457 \text{ цаг} : 8 \text{ цаг} = 41307.1$ ажлын өдөр : $200 \text{ ажлын өдөр}^4 = 206,5$ хүн

Өөрөөр хэлбэл “улсын хэмжээнд бичиг баримтын шинжилгээг хамгийн багадаа 1 объекттой шинжилгээ хийнэ гэж үзэн” чиг үүргийг хэрэгжүүлэхэд Шүүхийн шинжилгээний байгууллагад 206,5 хүн буюу ойролцоогоор 206 албан хаагчийн орон тоо нэмэгдэх шаардлагатайг тооцоолов.

1.5 Криминалистикийн дүр зураг, дүрс бичлэгийн шинжилгээг хийж дүгнэлт гаргахад шаардлагатай хүний нөөцийн тооцоо:

Хүснэгт 11

⁴ Тооцоог нэг жилээр гаргаж байгаа бөгөөд Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийг баримталсан болно.

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа		Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /минутаар/
		минутаар	цагаар		
Криминалистикийн шинжилгээг хийж дүгнэлт гаргах	Шинжилгээ хийлгэх тухай мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, улсын байцаагчийн хүсэлт, объектыг хүлээн авах, танилцах	15		1466	21990
	Хүсэлттэй танилцаж, шинжилгээний объектод үзлэг хийх	60		1466	87960
	Шинжилгээний мэдээллийн хуулбарлан авах	10		1466	14660
	Шинжилгээнд шаардлагатай хэлбэрээр хөрвүүлэх	60		1466	87960
	Шинжилгээг хийх	360		1466	527760
	Гэрэл зургийн үзүүлэлт хийх	120		1466	175920
	Дүгнэлт бичих	180		1466	263880
	Дүгнэлт хэвлэх	20		1466	29320
	Дүгнэлтийг танилцуулж хаалгах	15		1466	21990
	Дүгнэлт хүлээлгэн өгөх хугацаа	15		1466	21990
НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА					1253430

Шинжилгээ хийлгэх хүсэлт, объектыг хүлээн авч танилцах хугацаа нь тухай шинжилгээний цар хүрээ объектийн тооноос шууд хамаарч харилцан адилгүй байдаг тул дунджаар тооцсон болно.

Тохиолдлын тоог сүүлийн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд сүүлийн 6 жилийн хугацаанд хийсэн шинжилгээний дундаж тоогоор тооцов.

Шаардлагатай хүний нөөц = 1253430 минут : 60 = 20890,5 цаг : 8 цаг = 2611,3 ажлын өдөр : 200 ажлын өдөр⁵ = 13,0 хүн

Өөрөөр хэлбэл “улсын хэмжээнд дүр зураг, дүрс бичлэгийн шинжилгээг хамгийн багадаа 1 объекттой шинжилгээ хийнэ гэж үзэн” чиг үүргийг хэрэгжүүлэхэд Шүүхийн шинжилгээний байгууллагад 13,0 хүн буюу ойролцоогоор 13 албан хаагчийн орон тоо нэмэгдэх шаардлагатайг тооцоолов.

⁵ Тооцоог нэг жилээр гаргаж байгаа бөгөөд Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийг баримталсан болно.

Криминалистикийн шинжилгээг хийж дүгнэлт гаргах нэгдүгээр үүргийн хүрээнд Шүүхийн шинжилгээний байгууллагад 527 албан хаагчийн орон тоо нэмэгдэх шаардлагатайг тооцоолов.

2. Шүүх эмнэлгийн шинжилгээ хийж дүгнэлт гаргахад шаардлагатай хүний нөөцийн тооцоо:

2.1 Шүүх эмнэлгийн цогцост хийх шинжилгээ хийж дүгнэлт гаргахад шаардлагатай хүний нөөцийн тооцоо:

Хүнэгт 12

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа		Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /минутаар/
		минутаар	цагаар		
Шүүх эмнэлгийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах	Шинжилгээ хийлгэх тухай мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, улсын байцаагчийн хүсэлтийг хүлээн авч, болсон хэргийн талаар мэдээлэл авах	30		4047	121410
	Шинжилгээг төлөвлөх, бэлтгэх	10		4047	40470
	Цогцост гадна үзлэг хийх	30		4047	121410
	Цогцсыг задалж, шинжилгээнд бэлтгэх	45		4047	182115
	Цогцосны дотор эрхтэний шинжилгээ хийх	120		4047	485640
	Сорьц авч лабораторид илгээх бичиг бичих	20		4047	80940
	Эд эсийг зүсэж шинжилгээнд бэлтгэх	20		4047	80940
	Цогцсыг эргэж хэвийн байдалд оруулж, угааж цэвэрлэх	30		4047	121410
	Шинжилгээний протокол бичих	120		4047	485640
	Лабораторийн шинжилгээний хариутай танилцах	20		4047	80940
	Гэрэл зургийн үзүүлэлт хийх	60		4047	242820
	Дүгнэлт бичих	90		4047	364230

	Дүгнэлт хэвлэх	20		4047	80940
	Дүгнэлтийг танилцуулж хаалгах	60		4047	242820
	Дүгнэлт хүлээлгэн өгөх хугацаа	15		4047	60705
НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА					2792430

Тохиолдлын тоог Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд сүүлийн 6 жилийн хугацаанд хийсэн шинжилгээний дундаж тоогоор тооцов.

Шаардлагатай хүний нөөц = 2792430 минут : 60 = 46540,5 цаг : 8 цаг = 5817,5 ажлын өдөр : 200 ажлын өдөр⁶ = 29,0 хүн

Өөрөөр хэлбэл “улсын хэмжээнд цогцост задлан шинжилгээг хийх” чиг үүргийг хэрэгжүүлэхэд Шүүхийн шинжилгээний байгууллагад 29,0 хүн буюу ойролцоогоор **29** албан хаагчийн орон тоо нэмэгдэх шаардлагатайг тооцоолов.

2.2 Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох амбулаторийн болон гадуур үзлэг шинжилгээ хийж дүгнэлт гаргахад шаардлагатай хүний нөөцийн тооцоо:

Хүснэгт 13

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа		Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /минутаар/
		минутаар	цагаар		
Шүүх эмнэлгийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах	Шинжилгээ хийлгэх тухай мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, улсын байцаагчийн хүсэлтийг хүлээн авах, танилцах	5		29291	146455
	Өгүүлэмж цуглуулах зовиур шаналгааг бичих	15		29291	439365
	Хохирогчийн байгаа эмнэлэгт очих, ирэх	120		29291	3514920
	Өвчтөний түүх болон шинжилгээтэй танилцаж бичлэг хийх	60		29291	1757460
	Үзлэг шинжилгээ хийх	20		29291	585820
	Дүгнэлт бичих	30		29291	878730
	Дүгнэлт хэвлэх	5		29291	146455
	Дүгнэлтийг танилцуулж хаалгах	30		29291	878730

⁶ Тооцоог нэг жилээр гаргаж байгаа бөгөөд Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийг баримталсан болно.

	Дүгнэлт хүлээлгэн өгөх хугацаа	5		29291	146455
НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА					8494390

Тохиолдлын тоог Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд сүүлийн 6 жилийн хугацаанд хийсэн шинжилгээний дундаж тоогоор тооцов.

Шаардлагатай хүний нөөц = 8494390 минут : 60 = 141573.1 цаг : 8 цаг = 17696.6 ажлын өдөр : 200 ажлын өдөр⁷ = 88,4 хүн

Өөрөөр хэлбэл “улсын хэмжээнд Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох амбулаторийн болон гадуур үзлэг шинжилгээ” хийх чиг үүргийг хэрэгжүүлэхэд Шүүхийн шинжилгээний байгууллагад 88,4 хүн буюу ойролцоогоор 88 албан хаагчийн орон тоо нэмэгдэх шаардлагатайг тооцоолов.

2.3 Хүний биед хийсэн бусад шинжилгээ /бэлгийн холбогдолтой, нас тогтоох/ тогтоох шинжилгээ хийж дүгнэлт гаргахад шаардлагатай хүний нөөцийн тооцоо:

Хүснэгт 14

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа		Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /минутаар/
		минутаар	цагаар		
